



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 138

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга
хэмжээний тухай

“Чингис хаан олон улсын нисэх буудал” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын 2017 он, 2018 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар тус үйлдвэрийн газар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтыг зөрчин 38.4 сая төгрөгийн ажил, гүйлгээг бүрдэл дутуу баримтаар хийсэн, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.2 дахь заалтыг тус тус зөрчин 29.4 сая төгрөгийн зардал, арга хэмжээг санхүүжүүлсэн, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, 8.5 дахь хэсэгт заасныг тус тус зөрчин 440.4 сая төгрөгийн худалдан авалтыг зохион байгуулсан зэрэг нийт 508.2 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Чингис хаан олон улсын нисэх буудал” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Чингис хаан олон улсын нисэх буудал” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирал Д.Мөнхбаатарт дотоод хяналтыг сайжруулж дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах;

2.2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтыг тус тус хэрэгжүүлэн ажиллаж, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар батлуулан, мөрдөж ажиллах;

2.3. Дотоодын авиа компаниудтай холбоотой үүссэн 11.0 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулах, шаардлагатай тохиолдолд хууль, шүүхийн байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;

2.4. Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөн ажиллах, зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байх;

2.5. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслэхдээ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс

0000391

урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам"-ын 8 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 53, 268 дугаар тогтоолыг баримтлан ажиллах, зохион байгуулах;

3. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар авах арга хэмжээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



А.АРИУНБОЛД

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн
138 дугаар тогтоолын хавсралт

6098169 + 1116262983

**“Чингис хаан олон улсын нисэх буудал” ТӨААТҮГ-т хийсэн
шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг
арилгах арга хэмжээний жагсаалт**

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах нэгж	Мөнгөн дүн /сая төгрөгөөр/	Зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ хийсэн	Санхүү, нягтлан бодох бүртгэлийн хэлтэс	38.4	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4 дэх заалтыг мөрдөн ажиллах
2	Үргүй зардал гаргасан	Санхүү, нягтлан бодох бүртгэлийн хэлтэс, Хэвлэл мэдээлэл, хуулийн хэлтэс	29.4	Төсвийн тухай хууль"-ийн 6.4.1-д заасан "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.2-д заасан "Төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх" заалтыг мөрдөн ажиллах
3	Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны зөрчил	Аж ахуй хангамжийн хэлтэс, Хэвлэл мэдээлэл, хуулийн хэлтэс	440.4	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хууль, холбогдох журмыг мөрдөж хэрэгжүүлэх
НИЙТ ДҮН:			508.2	